

ОЮУТНУУДЫГ ГАДААД ХЭЛЭЭР БИЕ ДААН УНШИЖ СУРГАХ НЬ ГАДААД ХЭЛИЙГ ЭЗЭМШИХ ЧУХАЛ НӨХЦӨЛ БОЛОХ НЬ

Ч.Батчимэг

ХСИС-н ЭЗНУС-н ГХТ-н ахлах багш,
магистр, цагдаагийн ахмад

Аннотация: В данной статье нами рассмотрена важность самостоятельного чтения студентов-нефилологов в процессе обучения иностранным языкам и предлагаем два этапа обучения чтению, которые уже дали результаты в учебной практике.

Түлхүүр үгс: уншуулж сургах, сургалтын хэрэгсэл, бичвэр, агуулга, танилцах, уншлага, гүйлгэн унших

Даяаршил мэдээлэл технологийн эрчимтэй хөгжлийн эрэн үед гадаад хэлний тархац хүрээ өргөжсөөр дэлхийн олон сая хүний харилцааны хэрэглүүр, мэргэжил боловсрол эзэмших хэрэглүүр болсон учраас улс төр, нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт мэдээлэл солилцож хамтран ажиллах олон боломжууд нээгдээд байна.

Боловсролын шинэчлэл нь орчин үеийн нөхцөлд гадаад хэлийг зааж сургах асуудалтай шууд холбоотой болоод байна. Энэ нь сургалтын хөтөлбөрт шинэ технологи нэвтрүүлэхээс гадна суралцагчдын бие даан үйл ажиллагаа явуулах идэвхийг нь хөгжүүлэх ач холбогдолтой заах-арга зүйн материалуудыг шинээр бий болгохыг шаардаж байгаа юм.

Хэл сурах ерөнхий арга барилын хүрээнд мэдээллийн эрин зуунд амьдарч ажиллах мэргэжилтэнг бэлтгэхдээ тэдний унших чадварыг хөгжүүлэх, унших арга барилыг эзэмшүүлэх асуудал цаг үеийн шаардлагаар чухлаар тавигдаж байна.

Унших чадвар гэдэг нь бичмэл болон хэвлэмэл материалын бүрэлдэхүүн нэгжид задлан шинжилгээ хийж тухайн сэдвийн санааг ойлгох оюуны үйлийн чадвар юм. Уншиж ойлгох чадвар нь оюуны үйлдлийн талаасаа хүртэхүй (perception) болон сэтгэхүй (thought) хоёрыг багтаасан цогц нарийн үйл юм. Бие даан уншиж ойлгоно гэдэг нь суралцагчийн зүгээс уншиж байгаа зүйлээ урьдны мэдлэгтэй холбож ухаарах, үгийн олон салаа утгыг зөв тодорхойлж ойлгох, хэлний дүрмийн мэдлэгээ ашиглах идэвхтэй үйл юм.

Үүнээс харахад унших чадвар нь оюуны болон танин мэдэхүйн олон үйлийн огтолцол дээр төлөвшдөг цогц чадвар болох нь харагдаж байна. Аливаа чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх ажлын үр нөлөө нь уг сургалтын явцад тэдний мэргэжлийн онцлогуудыг аль хэр бүрэн дүүрэн харгалзахаас шууд хамааралтай. Иймээс, гадаад хэлээр уншуулж сургах зорилтыг шийдвэрлэхдээ мэргэжлийн талаас ямар онцлог шаардлагууд байгааг юуны өмнө тогтоох шаардлагатай юм.

Хэлний бус мэргэжилтнүүдийн гадаад хэлний хэрэглээг судалж үзэхэд тэдний 95 орчим хувь буюу дийлэнх олонх нь унших хэрэгцээ шаардлагатай тулгарч байдаг бол мэргэжлийн талаас 75 орчим хувь нь гадаад хэлний хэрэглээгээ үүгээр хязгаарлагдаж байгаа нь унших үйл явцыг их дээд сургуулийн гадаад хэлний сургалтын хамгийн чухал зорилтуудын нэг хэмээн зүй ёсоор үзэх баталгаа болж байна.

Гадаад хэлний сургалтын явцад хэлний бус мэргэжлийн оюутануудад чиглэсэн тэднийг сургалтын үйл явцад идэвхтэй оролцуулан, хичээлийн хүрээнд хувийн зохион байгуулалттай болгодгийн үр дүнд үр дүнтэй мэдлэг олгох, хэлийг практик дээр эзэмших хандлагыг төлөвшүүлдэг байна. Хүмүүнлэгийн ухааны чиглэлийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн шаардлагуудыг судалж үзэхэд гадаад хэл дээрх эх сурвалж ашиглах нь ихэвчлэн дараах зорилготой байдаг байна. Үүнд

1. Тодорхой сэдвээр гарсан нийтлэлүүдтэй танилцах;
2. Гадаадын эрдэмтдийн гол чиг хандлагуудыг олж тогтоох;
3. Шинжилгээ судалгааны ажлын материал цуглуулах.

Суралцагчийн хувийн идэвхийг хөгжүүлэхэд голлох үүрэгтэй оролцдог багш төдийгүй оюутны бие даасан идэвхтэй үйл ажиллагааг хөгжүүлэхэд зориулан түүний санал болгож буй сургалтын материалууд мөн түлхэц болж байх ёстой юм. Хэлний бус мэргэжлийн оюутнуудын гадаад хэлний сургалтын нөхцөлийг харгалзан тухайн түвшинд тавигдах шаардлагуудыг

боломжит дээд хэмжээгээр багасгахын зэрэгцээ хоёр янзын аргаар уншуулж сургах зорилтыг бодитойгоор биелүүлэх тухай асуудлыг зайлшгүй тавих хэрэгтэй болдог.

Уншуулж сургах нь хэл ярианы бусад үйл ажиллагаануудын нэг адилаар сургалтын болон арга зүйн ерөнхий ба тусгай зарчмууд дээр тулгуурлаж байдаг. Уншуулж сургах нь хэл ярианд сургах үйл явц байх ёстой. Гадаад хэлний сургалтын үндэс суурь нь хэлийг харилцааны мөн чанарыг хүлээн зөвшөөрөх явдал байдаг.

Уншихын гол зорилго нь ойлгох явдал байдаг учир юуны түрүүнд уншиж буй зүйлээ ойлгоход ямагт чиглэсэн байх ёстой. Хэрэв унших нь ямар нэг өөр зүйлд, жишээлбэл эх бичвэрийн зарим зүйлсийг тодруулах, тэдгээрт дүн шинжилгээ хийх г.м., чиглэсэн байвал энэ нь сургалтын хэрэгсэл болж байгаа юм. Үүнийг биелүүлэхэд туслах үндсэн нөхцөлүүдийг дурдвал:

1. Юуны өмнө, уншихад зориулсан материалууд нь анхлан суралцах үеийн сурах бичгүүдэд заримдаа тохиолддог ямар нэг сэдэвтэй зураг дүрслэл бүхий үгсийн сангийн (зөв бичих дүрмийн) материал бус, харин харилцааны нэгж болохын хувьд эх бичвэрийн бүхий л шинжүүдийг агуулсан текст, бүтээлүүд байх ёстой. Сургалтын явцад төрөл бүрийн текстүүдийг уншихдаа чанарын хувьд ялгаатай шинжтэй мэдээллийг олж авах хэрэгцээ, шаардлагыг оюутнуудын өмнө тавьж байх хэрэгтэй юм.
2. Текстыг унших хэрэгцээ (сэдэл). Бие даан унших болон ярьж сурах арга барилыг хөгжүүлэхэд зориулан санал болгож буй текстүүд нь багшийн удирдлага доор анги танхимд явагддаг сургалтын ажлын явцад ашиглагдаж буй материалуудыг баримжаа болгосон байна. Бие даан унших үед гол анхаарал уншиж буй зүйлийн агуулга, урьд нь судлагдсан үгсийн сан болон зөв бичих дүрмийн материалыг шинэ нөхцөл байдалд таньж мэдэх, ойлгох, тэдгээрийг хослуулахад чиглэгдэнэ. Сургалтын материалын текстүүд нь дэс дараалсан системтэй байхаас гадна тексттэй холбогдуулан урьдаас тусгайлан бэлтгэсэн даалгавруудыг багтаасан байвал зохино.
3. Уншуулж сургах үйл явц нь суралцагч зөвхөн мэдээлэл авах бус тэдний бүтээлч үйл ажиллагааг багтаасан байх ёстой юм.
4. Уншиж буй зүйлээ ойлгоход сургах үйл явц нь хэлний бүтцийг (түүний бүтцийн болон зохион байгуулалтын элементүүдийг) сурч мэдэх, эзэмшихэд тулгуурласан байна.
5. Гадаад хэлээр уншуулж сургах үйл явц нь суралцагчдын эх хэлээрээ унших туршлага дээр тулгуурлана. Туршлагатай уншигчийн шинэ хэлээр уншиж сурах үйл явц нь эх хэлээрээ уншиж сурах үйл явцын хөгжлийн замыг давтдаггүй болох нь тогтоогдсон. Оюутнуудыг уншуулж сургах сургалтын үйл ажиллагааг аль болох богино хугацаанд бага хүч зарцуулан түүнд шаардлагатай чадвар, дадлаар хангах боломжтой байхаар төлөвлөх хэрэгтэй юм. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд их дээд сургуулиудын хичээлийн цагийн хуваарилалтын өнөөгийн нөхцөлд мэргэжлийн оюутнуудын гадаад хэлний сургалтын хөтөлбөрт тавигдаж буй шаардлагуудыг зайлшгүй эргэн харах хэрэгтэй байна хэлний бус.

Санал болгож буй дараах сургалтын үе шатууд нь нэлээд ирээдүтэй, ямартай ч зөв зүйтэй гэдэг нь практик дээр батлагдсаар байгаа юм. Үүнд:

Сургалтын 1-р үе шат (эхний 2 сар) – танилцах болон судлан унших аргыг хөгжүүлэх. Энд бүр анхнаас нь эдгээр хоёр төрлөөр, тэр тусмаа хэлний (үгсийн сангийн) шинэ материал агуулсан текстүүд дээр унших үйл явцад саад учруулахгүй хэмжээгээр эрчимтэй дадлагын ажил явуулж байх нь зүйтэй юм. Энэ шатанд тусдаа хэрэгжүүлэх зорилтууд гэвэл техник дадлуудыг өөрийн болгох болгох буюу танилцах уншлагын хурдыг хөгжүүлэх болон мэдэхгүй үгсийн утгыг тодорхойлох чадварыг хөгжүүлэх явдал болно.

Сургалтын 2-р үе шатанд буюу ойролцоогоор эхний семестрын дунд үеэс танилцах уншлагын зэрэгцээгээр эрж олох зорилготой уншлагыг оруулж, харин сургалтын хугацааны төгсгөл рүү үзэж харах төрлийг оруулна. Гүйлгэж унших уншлагын төрлийг уг шатны төгсгөл рүү оруулах болсон нь уншиж буй хүнээс харьцангуй нэлээд гүнзгий түвшний хэлний мэдлэг эзэмшсэн байхыг шаарддагатай юм.

Дүгнэлт:

Оюутнуудын илүү ихийг улам сайн мэдэх гэсэн эрмэлзлийн чухал хөшүүрэг болсон энэхүү сургалтыг амжилттай болох нь практик дээр батлагдсан бөгөөд амжилттай биелүүлсэн ажлаасаа авах суралцагчдын сэтгэл ханамж нь тэдэнд идэвхтэй бие даан унших сэдэлийг бий болгож, улмаар дараа дараачийн шатанд арай хүнд текстүүдийг унших үед ойлгох үйл явцыг хөнгөвчлөн

илүү хурдасгаж өгдөг билээ. Иймээс гадаад хэлний сургалтанд бие даан унших чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын материалыг өргөнөөр ашиглах нь суралцагсад сурах бичиг гарын авлагаас өөрийн мэдлэг, боловсрол, судалгааны ажилд шаардлагатай мэдээ, мэдээлэл материалыг олж, түүнийгээ өөрийн мэдлэг болгон авахад нь тустай болно.

Обучение студентов-нефилологов самостоятельному чтению важное условие успешного овладения иностранным языком.

Модернизация образования в современных условиях имеет непосредственное отношение и к преподаванию иностранного языка. Она предполагает не только внедрение в учебный процесс новых технологий, но и создания лингвометодических материалов, побуждающих учащихся к самостоятельной деятельности. Эффективность подготовки специалистов любого профиля находится в прямой зависимости от того, насколько полно в процессе этой подготовки учитываются особенности профессиональной деятельности. Поэтому, решая вопрос о задачах обучения чтению на иностранном языке, необходимо прежде всего выяснить, каковы же профессиональные потребности специалистов в этой области. Изучение фактического использования иностранного языка специалистами-нефилологами показывает, что подавляющему из них более 95% приходится читать, причём примерно для 75 % применение иностранного языка в профессиональных целях этим ограничивается, что подтверждает правомерность рассмотрения чтения как одной из важнейших задач вузовского курса иностранного языка.

В преподавании иностранного языка формируется личностно ориентированный подход к студенту – нефилологов предполагающий его активную вовлечённость в учебный процесс, формирование самоорганизации в рамках учебных занятий, как следствие этого – эффективное усвоение знаний, улучшение практического владения языком. Исследование профессиональных потребностей специалистов гуманитарного профиля показывает, что использование источников на иностранном языке чаще всего преследует следующие цели:

1. Знакомство с публикациями по определенной проблеме;
2. Выяснение основных тенденций направлений зарубежных
3. Подбор материала для научной работы

Этому должен способствовать как сам преподаватель, которому принадлежит определяющая роль в развитии личной активности учащегося, так и предлагаемые им учебные материалы, активизирующие самостоятельную деятельность студента. Учитывая условия обучения иностранному языку студентов – нефилологов приходится ставить вопрос о максимально допустимой минимизации требований к уровню владения, но при этом такой, при которой решение двух способов чтения было бы реально выполнимым. Обучение чтению, как и другими видами речевой деятельности, строится как на дидактических, так и на методических – общих и частных принципах. Обучение чтению должно представлять собой обучение речевой деятельности. Основоположающим для обучения иностранному языку является признание коммуникативной природы языка. Цель чтения является понимание, и то это означает, что оно всегда должно быть направлено в первую очередь на понимание читаемого. Если чтение направлено на что-нибудь иное, например, на выделение каких-либо элементов текста, их анализ и т.д., то оно выступает как средство обучения. Перечислим основные условия, которые способствуют реализации этого положения. Перечислим основные условия, которые способствуют реализации этого положения.

1. Прежде всего материалы для чтения должны быть текстами, речевые произведениями, овладевающими всем признаками текста как единицы коммуникации, а не иллюстрациями лексического материала (грамматического) на ту или иную тему, как это иногда имеет место в учебниках для начального периода обучения. В период обучения надо ставить учащихся перед необходимостью извлекать различную, и по количеству и по качественным характеристикам информацию при чтении разных текстов.
2. Потребность (мотивация) прочитать текст может быть и предлагаемые тексты для развития навыков самостоятельного чтения и говорения ориентированы на материал, предлагаемый ранее в процессе аудиторной работы под руководством преподавателя. Основное внимание при самостоятельном чтении направлено на содержательную сторону читаемого, узнавание и понимание уже

известного лексика и грамматического материала в новых ситуациях и комбинация. Система текстов пособия по следователна и включает преоделевать специально составленные предтекстовые задания.

3. Обучение чтению должно включать наряду с рецептивно, (ре)продуктивную деятельность учащегося.
4. Обучение пониманию читаемого должно опираться на овладение структурой языка (его структурными и строевыми элементами)
5. Обучение чтению на иностранном языке должно опираться на опыт учащихся в чтении на родном языке.

Известно, что у опытного чтеца становление чтения на новом языке не повторяет пути развития чтения на родном языке.

Обучение чтению должен быть спланировано так чтобы возможно быстрее и с наименьшей затратой сил обеспечить у студентов необходимых для этого умений. В условиях университетского распределения часов решение этой задачи нуждается в пересмотре программных требований по иностранному языку для студентов-нефилологов.

Одним из перспективных, во всяком случае оправдывающим себя на практике, являются предлагаемые ниже этапы обучения:

Первый этап обучения (первые два месяца) – развитие ознакомительного и изучающего чтения. Здесь с самого начала вести интенсивную практику в обоих этих видах, в том числе и на текстах, содержащих новый языковой (лексический) материал, разумеется, в пределах не нарушающих процесса чтения. Более частными задачами на этом этапе являются: автоматизация технических навыков – развитие скорости ознакомительного чтения и развитие умений определять значения неизвестных слов.

На втором этапе обучения, примерно с середины первого семестра, параллельно с ознакомительным, вводится поисковое чтение, а ближе к концу курса обучения – просмотровое. Отнесение просмотрового чтения на конец этапа вызвано тем, что его функционирование требует от читающего владения довольно большим по объёму языковым материалом.

Практика подтвердила успешность этого обучения, которое явилось важным стимулом в стремлении учащихся знать лучше и больше, а удовлетворение от удачно выполненной работы побуждает учащихся к активной самостоятельной деятельности чтения, облегчает и ускоряет процесс понимания при чтении более сложных текстов и следующих этапах обучения.